

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Орон сууцны хууль,
эрх зүйн орчны тойм судалгаа



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

Улаанбаатар хот
2017 он

ОРОН СУУЦНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**ГҮЙЦЭТГЭГЧ: ӨМГӨӨЛЛИЙН “МОНГОЛИАН ЛЕГАЛ ЭКСПЕРТС” ХХН-
ИЙН ЗӨВЛӨХ БАГ:**

Хуульч, өмгөөлөгч: Анбатын Дэлгэрмаа
Хуульч, өмгөөлөгч: Баасангийн Лхамсүрэн
Хуульч, өмгөөлөгч: Гансүхийн Оргилмаа
Хуульч, өмгөөлөгч: Хөхөөгийн Хажидсүрэн

Агуулга	Хуудасны дугаар
1. I хэсэг. Танилцуулга	5-10
2. II хэсэг. судалгаа, дүгнэлт, санал	11-29
3. III хэсэг. Хавсралт 1 /Аргачлал, нэгдсэн дүн/	30-31
4. Хавсралт 2 /Холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт/	32-52

Товчилсон үгийн жагсаалт

- ААҮАТЗТХ-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- БОНБҮТХ-Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль
- БОНБҮ-Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ
- БОЕҮ-байгаль орчны ерөнхий үнэлгээ
- БОНҮ- байгаль орчны нарийвчилсан үнэлгээ
- ГЗБХОТ, ТОСГОНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
- ЗЗНДНТУТХ-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай
- ИДБ-инженерийн дэд бүтэц
- ОНИТХ-Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- УИХ-Улсын Их Хурал
- СӨХНЗОСДӨЭХТХ-Сууц өмчлөгчдийн холбоо, нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
- ТЗТБ-Төрийн захиргааны төв байгууллага
- ТЗБ-Төрийн захиргааны байгууллага
- ХБТХ-Хот байгуулалтын тухай хууль
- ХТХХОТ, ТОСГОНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
- ХБББ-Хот байгуулалтын баримт бичиг
- ХБТН-хот байгуулалтын техникийн нөхцөл
- ХТСС-хот төлөвлөлтийн суурь судалгаа
- ХСДХТ-хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл

I. ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАНИЛЦУУЛГА

Судалгааны арга, аргачлал:

- Баримт бичиг судлах; задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх; харьцуулалт хийх /synopse/
- Орон сууцны тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”¹

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг шалгах дараалал:

1. Давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
2. Орон сууцы тухай хуулийг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх.

Ашигласан эх сурвалж:

- Хууль тогтоомж, эрх зүйн акт
- Хуулийн хувийн хэрэг, үзэл баримтлал
- Онолын ном, сурах бичиг
- Холбогдох вэб сайтуудын мэдээлэл

Холбогдох эрх зүйн акт:

Энэхүү ажлын хүрээнд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn цахим сайтаас **Орон сууц** зэрэг түлхүүр үгээр хайлт хийхэд шууд болон шууд бус хамааралтай доорх хууль, эрх зүйн актууд олдож байна. Үүнд:

- Хууль-87²
- УИХ-н тогтоол-44
- Олон улсын гэрээ-17
- Ерөнхийлөгчийн зарлиг-4
- УИХ-аас томилогддог байгууллага, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр-0
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр -19
- Улсын дээд шүүхийн тогтоол-11
- ЗГ-ын Тогтоол-205
- Сайдын тушаал-39
- Аймаг, нийслэлийн засаг даргын захирамж-2

Хуулийн ерөнхий бүтэц:

Орон сууцы тухай хууль нь 6 бүлэг, 19 зүйлтэй. Орон сууцыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

¹ Аргачлалыг судалгааны ажилд хавсаргав. Хавсралтаас үзнэ үү.

² Жагсаалтыг хавсралт 1-ээс үзнэ үү.

Нэмэлт, өөрчлөлт орсон байдал

Орон сууцы тухай хуулийг Улсын Их Хурлаас 1999 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр батлагдсан. Батлагдсан өдрөөс хойш 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Дээр дурдсан хууль, эрх зүйн актуудаас тус хуульд шууд хамаарах дараах хууль, эрх зүйн актууд байна.

Нийт	Тоо
Хууль	17
УИХ-ын тогтоол	22
Засгийн газрын тогтоол	105
Сайдын тушаал	12
НИТХ, НИТХТ-ийн тогтоол	1
НЗД-ын захирамж	2
УДШ-ийн шийдвэр	1

1.1. Орон сууцны товч түүх

Монгол Улсын хувьд нүүдлийн соёл иргэншилтэй улс бөгөөд орчин цагийн орон сууцанд амьдрах эхлэл хотжилттой зэрэгцэн бий болсон байна.

Манай улсад суурьшмал соёл иргэншлийн үндсэн хэв шинж, хот суурин хөгжиж ирсэн **Нэгдүгээр үе буюу 1911-1934 онд** манай улсад Их хүрээ-Цэрэг нийгэм–улс төр, худалдаа төвлөрсөн цайз бэхлэлт худалдааны **Ховд, Улиастай, Эрдэнэ Зуу, Хиагт хот**, Шашин, нийгэм-улстөр, соёлын томоохон төв **Хархорин, Амарбаясгалант хийд, Тариалтын хүрээ, Бэрээвэн хийд** зэрэг хот суурин байсан.

Хоёрдугаар үе шат буюу 1934-1960 онд анх үндэсний аж үйлдвэрийн суурь тавигдан хот байгуулалтын хөгжлийн шинэ үе эхэлсэн,

Гуравдугаар үе буюу 1960-1994 онд манай улсад социалист үйлдвэрлэлийн харьцаа бүрэн тогтож Аж үйлдвэр–ХАА орон болгон хөгжүүлэх чухал зорилт тавигдсан хотжилтын хөгжлийн онцлог үе байсан,

Дөрөвдүгээр үе буюу 1994 оноос Манай улс зах зээлийн нийгэм эдийн засгийн шинэ харилцаанд орж бүс нутгаар хөгжих дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлагыг эрхэмлэх болсон гэж үздэг.

1.2. Монгол улсын орон сууцны эрх зүйн орчин

1998 онд Орон сууцны тухай хуулийн төсөл, орон сууц хувьчлах болон Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байжээ. Дээрх хуулийн үзэл баримтлалд орон сууцны хангамжийн тухайн үеийн байдлын талаар дурдахдаа Улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн үр дүн нь хүн амын амьдралын түвшингээр илэрхийлэгдэж түүнийг дээшлүүлэх нь төр засгийн бодлогын цөм болж байдаг бөгөөд үүнд хүний амьдралын **анхдагч хэрэгцээ болсон орон сууцны** асуудал чухал байр суурь эзэлдэг билээ.

Монгол Улсад манай улсад социалист үйлдвэрлэлийн харьцаа бүрэн тогтсон буюу 1960-аад оноос хотжих үйл явц маш хурдацтай явагдаж хот суурин газарт суурьшин амьдрах хүн амын тоо байнга өсөж одоогийн байдлаар нийт хүн амын 55 хувь нь суурин газар амьдарч байгаагаас 26 хувь нь нийслэл хотод амьдарч байна. Энэ нь монгол оронд нүүдлийн соёл иргэншлийн эзлэх байр суурь аажмаар багасаж суурин соёл иргэншил рүү түлхүү шилжих хандлага гарч ирснийг харуулж байна.

Монгол орны бүх хот суурин газрын хөгжлийн түвшинг орон сууцных нь хувьд бүхэлд нь авч үзвэл үндсэн 3 төрөлд хувааж болох бөгөөд энэ нь:

1. Иж бүрэн үйлчилгээтэй нийтийн зориулалттай орон сууцны олон давхар барилга бүхий хороолол
2. Гэр болон хувиараа барьсан сууц бүхий гэр хороолол
3. Шинээр үүсч байгаа тохилог амины орон сууцны хороолол юм.

Тухайн үед хүн амын орон сууцны хангамж Улаанбаатар хотод 49.3%, Дархан-Уул аймагт 59.6%, Орхон аймагт 61% бусад аймгуудад дунджаар 15.2%-тай байна. Улсын хэмжээнд нийт өрхийн 64% нь гэрт, 22 % нь орон сууцанд, 1 орчим хувь нь зураг төслийн дагуу баригдсан амины орон сууцанд, 13% нь иргэд өөрсдийн боломжоор хувиараа барьсан сууц орж байгаа юм. Иймд нийт өрхийн 78% нь орон сууцны үндсэн нөхцөл шаардлагыг хангаагүй орчинд буюу гэр хороололд амьдарч байгаа бол 23 % нь ямар нэг хэмжээгээр орон сууцаар хангагдсан гэж үзэж болох юм.

Орон сууцанд амьдарч байгаа иргэдийн нэг хүнд ногдох сууцны талбай нь эрүүл ахуйн шаардлагад тулгуурласан олон улсын жишиг дундаж хэмжээгээр 15-20 м² байдаг бол энэ үзүүлэлт хотод 7,7 м², хөдөөд 5,6 м² байна. Энэ нь орон сууцны хангамжийн дараагийн шатны үзүүлэлт болох **чанар** бөгөөд өөрөөр хэлбэл нэг хүнд ногдох сууцны талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар амьдрах **орчныг** сайжруулах асуудал юм.

Аливаа орны эдийн засгийн байдал сэргэх тусам орон сууцны хөгжлийн хэтийн хандлагыг зөв чиглүүлэх үндэс гэж үзнэ.

- Иймд орон сууцны санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгох нь хүн амын орон сууцны хангамжийг тухайлбал нийгмийн эмзэг хэсэг, төрийн албан хаагчдын орон сууцны цогцолбороор шийдвэрлэх нөхцөл бүрдүүлэхээр,
- Хуулийн төслийг боловсруулахдаа улс орны нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөж эдийн засгийн чадавх хүнд хэцүү байгаа өнөөгийн үеийн байр сууринаас бус улс орны хөгжлийн хэтийн хандлагыг харгалзан хүн амын бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн үндсийг бүрдүүлэхийг чухалчлан үзэхээр,
- Монгол улсын Үндсэн хуулийн "...Монгол улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй..." гэсэн заалт нь хүний амьдарч, аж төрөх ахуй орчныг бүрдүүлэгч орон сууцанд тавигдаж байгаа үндсэн шаардлага бөгөөд энэ ч утгаараа Орон сууцны тухай хууль нь Үндсэн хуулийг хэрэгжүүлэх нэгэн хэсэг гэж үзэхээр тус тус тусгажээ.

Тухайн үед Хуулийн төслийг боловсруулахын тулд Англи, Канад, Япон, Оросын Холбооны улсын орон сууцны бодлого, чиглэл, холбогдох материалуудыг судалж, танилцсанаас гадна Азийн хөгжлийн банк, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Дэд бүтцийн хөгжлийн яам, Хууль зүйн яам, Төрийн өмчийн хороо, Нийтийн аж ахуй үйлчилгээний газар / хэрэгжүүлэгч агентлаг/, Барилга архитектурын газар, Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн компанийн холбогдох ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг санал өгч ажиллажээ.

Одоогийн орон сууцны эрх зүйн зохицуулалттай холбогдох харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Орон сууцны тухай, Газрын тухай, Орон сууц хувьчлах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Гэр бүлийн тухай, Дайчилгааны тухай, Онц байдлын тухай, Ирээдүйн тэтгэврийн

нөөц сангийн тухай, Хог хаягдлын тухай, Эрчим хүчний тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай, Барилгын тухай хууль болон төрийн бодлогын баримт бичгүүд орон сууцны норм ба дүрэм зэрэг хууль тогтоомж, хэм хэмжээний актын хүрээнд зохицуулагдаж байна.

Монгол Улсын үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлээр:

- эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;
-

Иргэний хуулиар Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрх, нийтийн зориулалттай орон сууц өмчлөх, Сууц өмчлөгчдийн холбоо, Холбоог татан буулгах, Орон сууц дангаар өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох, Орон сууцны дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйл, Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах, Орон сууц өмчлөгчийн эрх, үүрэг, Бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийн талаар,

Орон сууц хувьчлах тухай хуулиар төрийн өмчийн орон сууцыг иргэдэд хувьчлах явцад төрийн эрх бүхий байгууллага иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахаар,

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай сууц өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулахаар,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, түүний эдэлбэр газар, нийгэм эдийн засгийн үндэс, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад байгууллага, оршин суугчтай харилцах харилцааг,

Барилгын тухай хуулиар барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар,

Эрчим хүчний хуулиар эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл

ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэх талаар,

Хот, суурины үс хангамж, ариутгах татүүргын ашиглалтын тухай хуулиар хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглах талаар,

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэл хот, түүний онцлог чиг үүрэг, нийслэлийн нутаг дэвсгэр, хотын эдэлбэр газар, нийслэлийн өмч, төсөв, нийслэл хотын оршин суугч, түүний үүрэг нийслэлийн удирдлага, эрх, байгууллага, иргэд хоорондын харилцааг,

Хот байгуулалтын тухай хуулиар Монгол Улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн ам, нутагшилт суурьшлын зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, байгууллага, иргэний харилцааны зохицуулалтыг,

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиар хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг тус тус зохицуулж байна.

II. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ ХИЙДЛИЙН СУДАЛГАА³

2.1. ДАВХАРДАЛ

7.1.2.Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Барилгын тухай хууль 2016.02.05 <i>/Шинэчилсэн найруулга/</i>
1.	<p>15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх. 15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно. <i>/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>	<p>46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг</p> <p>46.1.3.барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх;</p> <p><u>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</u></p> <p><u>4.1.1.“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;</u> <i>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>
<p>Дүгнэлт: Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуульд барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөхгүй байх талаар агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна. Барилгын тухай хуулийн 4.1.1-д <u>“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; гэж томьёолсон тул Орон сууцны тухай хуулийн 15.1-д давтан зохицуулах шаардлагагүй.</u></p> <p>Санал: Орон сууцны тухай хуулийн 15.1 дэх хэсэгт Барилгын тухай хуулийн 46.1.3 дахь заалтыг эшлэх.</p>		

³ Энэхүү судалгаанд Хууль зүй, дотоод хэргийн яам болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн хууль тогтоомжийн эрх зүйн орчныг баталгаажуулах төслийн хуулийн хийдэл, зөрчил, давхардлын тайлангаас авч ашигласан болно. Орон сууцны хуулийн шинэчилсэн найруулгын зөвлөх үйлчилгээний багийн зүгээс өөрсдийн нэмэлт санал, дүгнэлтүүдийг тусгаж бэлтгэлээ.

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/
2.	<p>7 дугаар зүйл.Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>7.1.2.орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, дүрэм, журам батлах, стандарт хянах, мөрдүүлэх;</p> <p><i>/Энэ заалтад 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хууль, 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>33 дугаар зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>33.1.2.энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлах;</p> <p><u>5 дугаар зүйл. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг</u></p> <p><u>5.1.1.барилгын норм, дүрэм;</u></p> <p><u>5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;</u></p> <p><u>5.1.3.стандарт.</u></p>
<p>Дүгнэлт: Барилгын тухай хуулийн 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг; гэж томъёолсон. Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуульд барилга байгууламжийн норм, дүрэм, журам батлах эрхийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулан зохицуулсан нь агуулгын хувьд давхардсан зохицуулалт байна.</p> <p>Санал: Орон сууцны тухай хуулийн 7.1.2-д Барилгын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг эшлэх.</p>		

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/
3.	<p>14 дүгээр зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн засвар, үйлчилгээ</p> <p>14.5.Орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахыг хориглоно.</p>	<p>46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг</p> <p>46.1.7.барилга байгууламжийн орчны тохижилтын засвар арчлалтыг тогтмол хийж, авто болон явган хүний зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахгүй байх;</p>

Дүгнэлт: Барилгын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд орон сууцны орчны зам, талбайн хөдөлгөөнийг хааж бусдад саад учруулахгүй байх талаар агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна.

Санал: Орон сууцны тухай хуулийн 14.5-д Барилгын тухай хуулийн 46.1.7 дахь заалтыг эшлэх.

2.2. ЗӨРЧИЛ

7.2.1. тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	БАРИЛГЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/
1	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1."орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг;</p> <p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. <i>/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</i></p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1."барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;</p> <p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>

Дүнэлт: Дээрх 2 хуулийн зорилгыг харахад орон сууцыг барихаас ашиглалтад өгөх хүртэл харилцааг барилгын тухай хуулиар ашиглалтад орсон орон сууцыг ашиглахтай холбоотой харилцааг Орон сууцны хуулиар зохицуулахаар харагдаж байна. Харин Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг гэсэн зүйлд барилга байгууламжийн ашиглалтын үеийн өмчлөгч эзэмшигчийн эрх үүргийг заасан нь оновчтой эсэхийг анхааран үзэх шаардлагатай байна. Түүнчлэн 46 дугаар зүйлд заасан үүргийг Орон сууцны тухай хуульд эшлэх шаардлагатай

№	Орон сууцны тухай	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2.	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. <i>/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</i></p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1."орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 2 дугаар зүйл.Орон сууцны тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 4 дүгээр зүйл.Төрөөс орон сууцны талаар баримтлах зарчим</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРОН СУУЦНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮРЭН ЭРХ 5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх 6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 7 дугаар зүйл.Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 7¹ дүгээр зүйл.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 8 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх 8¹ дүгээр зүйл.Мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг</p> <p>ГУРАВДУГААР БҮЛЭГ ОРОН СУУЦ, ТҮҮНИЙ ДЭД БҮТЦИЙГ ТӨЛӨВЛӨХ</p> <p>9 дүгээр зүйл.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө</p> <p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРОН СУУЦ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ</p>

	амины орон сууцны байшин, сууц, гэрийг;	<p style="text-align: center;">САНХҮҮЖҮЛЭХ</p> <p style="text-align: center;">11 дүгээр зүйл.Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх</p> <p style="text-align: center;">ТАВДУГААР БҮЛЭГ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН АШИГЛАЛТ</p> <p style="text-align: center;"><i>/Энэ бүлгийн гарчигт 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>14 дүгээр зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн засвар, үйлчилгээ</p> <p>14¹ дүгээр зүйл.Орон сууцны байшингийн инженерийн хангамж, орчны тохижилт</p> <p>15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх</p> <p>15¹ дүгээр зүйл.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууц</p> <p>16 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх</p> <p>17 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглох</p> <p style="text-align: center;">ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ</p> <p>18 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>19 дүгээр зүйл.Маргаан хянан шийдвэрлэх</p>
<p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуульд "орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг хэлэхээр заасан. Харин хуулийн зохицуулалт нь ерөнхийдөө нийтийн орон сууцны байшин, түүний ашиглалттай холбоотой асуудлыг зохицуулсан байна. Яамны зүгээс орон сууцны тухай хуулийг нэр томъёоны хүрээнд өргөн хүрээний зохицуулалт хийх үү эсхүл зорилгын хүрээнд явцуу утгаар нь зохицуулах уу гэдэг дээр байр сууриа илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.</p>		

7.2.8.Тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх:

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 2011.10.06 /Шинэчилсэн найруулга/	Эрчим хүчний тухай хууль 2001.02.01
1.	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо</p> <p>3.1.7.“хэрэглэгч” гэж Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.8, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.13-т заасан иргэн, хуулийн этгээдийг;</p>	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.8.“бохир усны гаргалгааны шугам” гэж хэрэглэгчийн сантехникийн хэрэгслээс барилгын гадна талын эхний худаг хүртэлх шугам сүлжээг;</p> <p>3.1.13.“хэрэглэгч” гэж цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан</p>	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.13.“дулаан дамжуулах сүлжээ” гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг;</p>

		зайлуулах үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;	3.1.19.“хэрэглэгч” гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчийг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг;
--	--	--	---

Дүгнэлт: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.8 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.13 дахь заалтыг Орон сууцны тухай хуулийн 3.1.7-д авсан нь эшлэлийн дугаартай нийцэхгүй байна. / Эрчим хүчний тухай хууль 2001.02.01-ний өдөр батлагдсан, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 2011.10.06-нд /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Орон сууцны тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулаагүй байна./

Санал: Орон сууцны тухай хуулийн 3.1.7-д Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.13 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.19 дэх заалтыг тус тус эшлэх.

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 2011.10.06 /Шинэчилсэн найруулга/	Эрчим хүчний тухай хууль 2001.02.01
2.	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.8.“хангагч” гэж Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.9, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.12-т заасан хуулийн этгээдийг; <i>/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.9.“бохир ус цуглуулах шугам” гэж барилгын гадна талын эхний худгаас бохир ус татан зайлуулах шугамд холбогдож байгаа худаг хүртэлх шугам сүлжээг; 3.1.14.“хангагч” гэж цэвэр усыг олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх үйлчилгээг бүхэлд нь, эсхүл аль нэгийг нь үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.12.“төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм” гэж төвлөрсөн дулаан хангамжийн бүрэлдэхүүн хэсгийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг; 3.1.16.“эрчим хүчээр хангагч” гэж эрчим хүчний зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

Дүгнэлт: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.9 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.12 дахь заалтыг Орон сууцны тухай хуулийн 3.1.7-д авсан нь тухайн хуулийн нэр томъёоны тодорхойлолттой нийцэхгүй байгаа буюу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг 2011.10.06-нд шинэчлэн найруулсантай холбогдуулан Орон сууцны тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулаагүй байна.

Санал: Орон сууцны тухай хуулийн 3.1.8-д Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.14 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.16 дахь заалтыг тус тус эшлэх.

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/
3.	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.5.“орон сууцны байшингийн орчны тохижилт” гэж Барилгын тухай хуулийн 3.1.11-д заасан барилгын орчны тохижилтыг; <i>/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/</i></p>	<p>3 дугаар зүйл. Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим</p> <p>3.1.Барилгын салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд дараахь зарчмыг баримтална: 3.1.1.барилгын үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрлийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулах; 3.1.2.барилгын үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.25.“гадна тохижилтын ажил” гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;</p>

Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 3.1.5-д 2008 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 3.1.11 дэх заалтыг эшлэсэн. 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 3 дугаар зүйл нь 3.1.1, 3.1.2 гэсэн 2 заалттай болсон.

Санал: Хуулийн 3.1.5-д Барилгын тухай хуулийн 4.1.25 дахь заалтыг эшлэх.

7.2.12.Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх;

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль 2003.06.18	МУ-ын Дээд Шүүхийн Зөвлөмж 2011.06.30 Дугаар 01
1.	<p>15 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх.</p> <p>15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно.</p> <p><i>/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан</i></p> <p>15.3.Орон сууцны байшингийн техникийн өрөөний зориулалтыг өөрчлөхийг хориглоно.</p>	<p>7 дугаар зүйл.Холбооны эрх барих дээд байгууллага</p> <p>7.2.9.сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барих;</p> <p>12.4.5.дундын өмчлөлийн эд хөрөнгийг түрээслүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах талаарх гэрээг холбооны нэрийн өмнөөс байгуулах;</p>	<p>Сууцны бус зориулалттай техникийн өрөөнд байгаа айл өрхөд захиргааны байгууллага, албан тушаалтан орон сууц эзэмших, өмчлөх эрхийг хууль бусаар олгосноос эрх хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөн хохирч байна.</p> <p>Цаашид энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд гарч байгаа алдаа зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтуудыг зөв тайлбарлан хэрэглэхэд тус дөхөм болох зорилгоор Шүүхийн тухай хуулийн ...дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх хэсгийн заалтыг үндэслэн Улсын Дээд Шүүхийн захиргааны хэргийн танхимаас Зөвлөх нь:</p> <p>Орон сууцны техникийн зориулалттай зарим өрөө доод хонгил, шатны доорх зайнд түрээсийн гэрээ, эзэмших эрхийн бичиг, зарим эрх бүхий албан тушаалтны бичгийн болон аман шийдвэрээр амьдралын гачигдалтай айл болон хүн амьдарч орон сууцны зориулалтаар түүнийгээ засан сайжруулж эзэмшсээр ирсэн ба одоо ч ийм айл өрх тэнд амьдарч байна. Эдгээр хүмүүс нь Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.4-т зааснаар тухайн байшинд үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ-ны гишүүн төдийгүй сууцны байшингийн дундын өмчлөлийн</p>

		<p>эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч мөн юм.</p> <p>Гэтэл зарим СӨХ-ны гүйцэтгэх захирал дундын өмчлөлийн эд хөрөнгө, орчны газрыг эзэмшдэг мэтээр ойлгож тэдгээр айл өрх иргэнийг гэрчилгээ эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр орон сууцыг ашиглаж байна, иргэний үүргээ биелүүлдэггүй, уг өрөө тасалгаа нь хүн, айл амьдархад зориулагдаагүй гэх зэрэг үндэслэлгүй хууль бус шалтгаан зааж, тэнд амьдрагсдыг гарахыг шаарддаг төдийгүй эрх бүхий этгээдээс олгосон орон сууц эзэмших, өмчлөх тухай шийдвэр гэрээ гэрчилгээг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа нь хууль бус юм. Өөрөөр хэлбэл өөрийн холбоонийхоо гишүүн төдийгүй сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч буюу үйлчлүүлэгчийнхээ эсрэг эрх хэмжээгээ хэтрүүлж байгаа үйлдэл гэж үзэхээр байна.</p> <p>Дээрх өрөө, сууцны болон тэнд амьдардаг айл өрхийн талаар хуулиар нарийвчлан зохицуулсан тодорхой заалт үндсэндээ байхгүй байсан боловч Улсын Их Хурлын 2003 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолын 2-т “орон сууцны байшин дахь техникийн өрөөг магадлан шинжлэх хэсгийн дүгнэлтээр хүн амьдрах шаардлага хангасан, орон сууцны зориулалтаар ашиглах боломжтой гэж тогтоогдсон тохиолдолд ...” хувьчилж болох тухай заалт нь төвөгтэй асуудлыг шийдвэрлэх гарц болсон байна.</p> <p>Иймд энэ асуудалд нэн болгоомжтой хандаж, анх тухайн өрөө тасалгаанд оруулсан, эрх олгосон этгээдийн шийдвэр нь</p>
--	--	---

		хууль, тогтоосон журамд нийцэж байгаа эсэх, мэргэжлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулахад саад болох, эрүүл мэндэд харшлах эсэх, тэнд амьдарсан хугацаа, өрөөний зориулалтыг өөрчлөхөд оруулсан хөрөнгийн хэмжээ зэргийг нарийвчлан тогтоох шаардлагатайн дээр эрх бүхий байгууллага албан тушаалтнаар дахин магадлагаа, дүгнэлт гаргуулах замаар маргааныг шийдвэрлэж байвал зохино.
<p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.3 дахь хэсэгт заасан орон сууцны техникийн өрөөний зориулалтыг өөрчлөхийг хориглох тухай заалттай СӨХЭЗБНЗОСБДӨЭХ-ийн тухай хуулийн холбогдох заалт болон УДШ-ийн 2011.06.30-ы өдрийн дугаар 01 дүгээр зөвлөмж, УИХ-ын 2003.06.18-ны өдрийн 27 дугаар тогтоол нь зөрчилдөж байна.</p> <p>Санал: СӨХЭЗБНЗОСБДӨЭХ-ийн 7.2.9, 13.2.7 дахь заалт, УДШ-ийн 2011.06.30-ы өдрийн дугаар 01 дүгээр зөвлөмж, УИХ-ын 2003.06.18-ны өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох.</p>		

7.2.13.Хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Барилгын тухай хууль 2016.02.05 /Шинэчилсэн найруулга/	СӨХЭЗБНЗОСБДӨЭХТ 2003.06.18
1.	15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх 15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно.	46 дугаар зүйл.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.1.3.барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх;	7 дугаар зүйл.Холбооны эрх барих дээд байгууллага 7.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. 7.2.Дараахь асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: <u>7.2.9.сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барих;</u>

			13 дугаар зүйл. Сууц өмчлөгчийн эрх, үүрэг 13.2.7.сууцныхаа зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй байх.
<p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.1, Барилгын тухай хуулийн 46.1.3-д орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглохоор заасан. СӨХЭЗБНЗОСБДӨЭХТухай хуулийн 7.2.9-д бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэсэн бол, 13.2.7-д эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй бол сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга бариж болохоор зохицуулсан нь Орон сууцны тухай хууль болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.</p> <p>Санал: СӨХЭЗБНЗОСБДӨЭХТухай хуулийн 7.2.9, 13.2.7 дахь заалтыг тус тус хүчингүй болгох.</p>			

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22	Зөрчлийн тухай хууль 2017.05.11
2.	15 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх 15.1.Орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглоно.	12.4 дүгээр зүйл.Орон сууцны тухай хууль зөрчих 1.Орон сууцны төлөвлөлт, барилгын үндсэн бүтэц, хийц, инженерийн шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслөөс өөрчилсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
<p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.1, Барилгын тухай хуулийн 46.1.3-д орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглохоор заасан.</p> <p>Санал: Зөрчлийн тухай хуулийн 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг хасах.</p>		

№	Орон сууцны тухай
3	7¹ дүгээр зүйл.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 7 ¹ .1.Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7 ¹ .1.1.төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 7 ¹ .1.2.орон сууцны төлөвлөлт, ашиглалтын норм, дүрэм, журам, стандарт боловсруулах, хэрэгжүүлэх; 7 ¹ .1.3.орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 7 ¹ .1.4.орон сууцны мэдээллийн сан бүрдүүлэн сүлжээ байгуулж, ажиллуулах.

/Дээрх 71 дүгээр зүйлийг 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

Дүгнэлт: Одоогийн байдлаар орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхгүй байна. Яамны зүгээс төрийн захиргааны байгууллага байх шаардлагатай эсэх дээр саналаа өгөх нь зүйтэй байна.

№	Орон сууцны тухай	ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/
4.	<p>9 дүгээр зүйл.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /Энэ зүйлийн гарчигт 2011 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</p> <p>9.1.Орон сууц, түүний дэд бүтцийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх арга хэмжээг орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>9.2.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд төв, суурины гэр хороолол, шинээр баригдах орон сууцны хороолол, барилгажсан хэсэг дэх орон сууцны хорооллыг хамруулна.</p> <p>9.3.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд орон сууц, түүний дэд бүтэц, орчны тохижилт, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжийн байршлыг иж бүрнээр тусгана.</p> <p>9.4.Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад дараахь шаардлагыг биелүүлнэ:</p> <p>9.4.1.тухайн нутаг дэвсгэрт орон сууцыг дэд бүтэцтэй нь хамт төлөвлөж хөгжүүлэх, орон сууц нэмж барихад түүнийг дэд бүтцийн сүлжээнд үр ашигтайгаар холбох;</p> <p>9.4.2.оршин суугчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах;</p> <p>9.4.3.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, үр дагавар гаргуулахгүй байх.</p> <p>9.5.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.</p> <p>9.6.Иргэдэд орон сууцны зориулалтаар газар олгоход орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэс болгоно.</p>	<p>3.1.12."хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг;</p> <p>3.1.14."шинэ хороолол, бичил хороолол" гэж эрх бүхий байгууллагын баталсан хот байгуулалтын баримт бичигт төлөвлөгдсөн, зориулалтын бүсчлэлийн дагуу хотын нутаг дэвсгэрт шинээр бий болох суурьшлыг;</p> <p>3.1.15."гэр хорооллын төлөвлөлт" гэж бие даасан болон төвлөрсөн инженерийн дэд бүтцээр хангагдсан суурьшлын төлөвлөлтийг;</p> <p>3.1.16."хот төлөвлөлтийн суурь судалгаа" гэж хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгч этгээд хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд газар нутаг, хүн ам, эдийн засаг, нийгэм, соёл, зам тээвэр, байгаль орчин, газар ашиглалт болон бусад зүйлийн талаар хийсэн судалгааг;</p>

	<p>9.7.Тухайн төв, суурин газарт орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгүй бол орон сууцны зориулалтаар газар олгоход энэ хуулийн 9.4-т заасан шаардлагыг биелүүлнэ.</p>	
--	--	--

Дүгнэлт: Хот байгуулалтын тухай хуулийн дагуу Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гэсэн ойлголт байдаг бөгөөд "хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг хэлдэг буюу хот байгуулалтын баримт бичгийг хэлдэг. Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлагыг мөн хуульд зааж өгсөн байдаг. Орон сууцны хуулийн хувьд хот байгуулалтын баримт бичигт хамаарч байгаа энэхүү төлөвлөлтийн баримт бичгийн асуудлыг зохицуулах нь хуулийн зорилттой болон Хот байгуулалтын тухай хуультай уялдаж байгаа нь эргэлзээ төрүүлж байна. Зүй нь энэ бүлэгт Хот байгуулалтын холбогдох зохицуулалт, Захиргааны ерөнхий хуулийн төлөвлөлттэй холбоотой зохицуулалтыг эшлэх нь зүйтэй байсан болов уу гэж үзлээ.

2.3. ХИЙДЭЛ

7.3.6 Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Зөрчлийн тухай хууль 2017.05.11	
1.	<p>12.4 дүгээр зүйл.Орон сууцны тухай хууль зөрчих</p> <p>1.Орон сууцны төлөвлөлт, барилгын үндсэн бүтэц, хийц, инженерийн шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслөөс өөрчилсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 15.1 дэх хэсэгт орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг шууд хориглож заасан байдаг.</p> <p>Санал: Тус хуульд орон сууцны үндсэн бүтэц, хийцийг анхны зураг төслийн байдалд эргүүлэн оруулах талаар зохицуулах.</p>

7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох ;

№	Орон сууцны тухай	Хөрөнгө оруулалтын тухай
1	<p>11 дүгээр зүйл.Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх <i>/Энэ зүйлийн нэрэнд 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</i></p> <p>11.1.Орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:</p> <p>11.1.1.улсын болон аймаг, нийслэлийн төсвөөс олгох хөрөнгө;</p> <p>11.1.3.олон улсын байгууллага, гадаад улс, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, хөрөнгө оруулалт;</p> <p>11.1.4.зээлийн үйл ажиллагааны орлого;</p> <p>11.1.5.үнэт цаас худалдсанаас олсон орлого;</p> <p>11.1.7.бусад эх үүсвэр.</p>	<p>5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр</p> <p>5.1.Хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;</p> <p>5.1.2.хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;</p> <p>5.1.3.компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.4.концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;</p> <p>5.1.5.санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.6.хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.</p>
<p>Дүгнэлт: Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ улсын болон аймаг, нийслэлийн төсвөөс олгох хөрөнгө; олон улсын байгууллага, гадаад улс, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, хөрөнгө оруулалт; зээлийн үйл ажиллагааны орлого; үнэт цаас худалдсанаас олсон орлого; бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр заажээ. Харин Хөрөнгө оруулалтын тухай хуульд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөс бусад хөрөнгө оруулалтын хэлбэрийг зааж өгсөн. Орон сууцны хуулийн хувьд хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хэлбэрүүдийг бусад эх үүсвэр гэсэн ангилалд оруулж хэрэглэж болох ч хуулийн</p>		

тодорхой байх шаардлагад дулдуйдан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийг Орон сууцны тухай хуульд эшлэх нь зүйтэй.

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22
2	<p>14¹ дүгээр зүйл.Орон сууцны байшингийн инженерийн хангамж, орчны тохижилт</p> <p>14¹.5.Гэрээт мэргэжлийн байгууллага нь оршин суугчдыг ус, дулаан, цахилгаанаар хангах зэрэг үйлчилгээний төлбөр, шимтгэлтэй холбогдсон санхүүгийн тайланг тухайн оршин суугчдад жил бүр тайлагнана.</p> <p>Дүгнэлт:Хуульд хэрэв тайланг хэлэлцүүлээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар тодорхойгүй байна. Санал: Зөрчлийн тухай хуульд нэмж оруулах.</p>

№	Орон сууцны тухай хууль 1999.04.22
3	<p>15¹ дүгээр зүйл.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууц</p> <p>15¹.5.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны сууц өмчлөгч нь хуучин орон сууцаа зах зээлийн үнээр хөрөнгө оруулагчтай тохиролцон худалдах, эсхүл нөхөн олговор авах эрхтэй.</p> <p>Дүгнэлт: Хуульд худалдан авах хөрөнгө оруулагч олдохгүй тохиолдолд хэрхэх талаарх харилцааг зохицуулаагүй, нөхөн олговортой холбогдсон асуудлаар ямар субъектэд хандах нь тодорхойгүй, тус харилцаа зохицуулагдаагүй байна. Санал: Хуульд энэ талаарх харилцааг зохицуулсан заалт нэмэх.</p>

7.3.8.Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх.

Орон сууцны тухай хууль 1999.04.22		СӨХЭЗБНЗОСБДӨЭХ-ийн тухай хууль 2003.06.18
1.	<p>14¹ дүгээр зүйл.Орон сууцны байшингийн инженерийн хангамж, орчны тохижилт</p> <p>14¹.1.Орон сууцны байшингийн инженерийн гадна шугам сүлжээ, дэд өртөө, ус, дулаан дамжуулах төв болон бусад үйлчилгээний газарт зарцуулсан хөрөнгийг орон</p>	<p>15 дугаар зүйл.Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө, дэвсгэр болон орчны газар</p> <p>15.1.Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд дараахь эд хөрөнгө хамаарна: 15.1.1.орон сууцны байшингийн гадна хана, даацын хана, багана, доод хонгил, дээвэр, дээврийн хонгил, цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууцны бус зориулалттай техникийн болон нэгдүгээр давхрын үйлчилгээний өрөө, сууц хоорондын талбай, түүний тагт, сууцны доторх дундын</p>

	<p>сууцны өртөгт оруулж тооцохыг хориглоно.</p> <p>14¹.2.Орон байшингийн тохижилтыг өмчлөгчдийн өмчлөлд шилжүүлнэ.</p>	<p>өмчлөлийн зүйл, тоног төхөөрөмж, орцны цонх, хаалга, довжоо, саравч, хог зайлуулах хоолой, орон сууцны байшингийн халаалт болон халуун, хүйтэн усны шугам сүлжээний удирдах зангилааны анхны хаалт, цахилгааны оролтын самбар, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, шалны +0.00 тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээнүүд, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг эд хөрөнгө;</p>
--	---	---

Дүгнэлт: Орон сууцны тухай хуулийн 14¹.2 дахь хэсэгт “Орон сууцны байшингийн орчны тохижилтыг дундын өмчлөлд шилжүүлнэ” гэж заасан бол СӨХЭЗБНЗОСБДӨЭХ-ийн тухай хуулийн 15.1.1 дэх заалтад орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн талаар заасан бол орон сууцны байшингийн орчны тохижилтыг дурдаагүй байна. Орон сууцны байшингийн орчны тохижилтыг сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд шилжүүлнэ гэдэг нь ойлгомжгүй байгааг тодорлуулах шаардлагатай байна.

№	САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Засгийн газрын 263 Дугаар тогтоол	ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД БАЙГУУЛАХ ТУХАЙ 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн Засгийн газрын 253 Дугаар тогтоол
2	<p>Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлоготой уялдуулан “Төрийн орон сууцны корпораци”-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах 100.0 (нэг зуун) сая хүртэл ам.доллартай тэнцэх хөрөнгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан 2013 онд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.</p> <p>2. “Төрийн орон сууцны корпораци”-ийн нийт орон сууцны санхүүжилтийн 50 хувийг хөдөө орон нутагт, 50 хувийг Улаанбаатар хотод санхүүжүүлэх чиглэл баримтлан ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрөөс иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Төрийн орон сууцны корпораци” (ТОСК) 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулсугай. 2. “Төрийн орон сууцны корпораци” хуулийн этгээдийн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Засгийн газарт танилцуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгасугай. 3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК-ийн чиг үүрэг, орон тоо, төсөв, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг “Төрийн орон сууцны корпораци”-д балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Ч.Улаан, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт тус тус даалгасугай. 4. “Төрийн орон сууцны корпораци” хуулийн этгээдийн үйл ажиллагааг

		<p>удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Иргэдийг орон сууцжуулах, ипотекийн зээлийн тогтолцоог бий болгох ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо (Н.Алтанхуяг)-нд үүрэг болгосугай.</p>
<p>Дүгнэлт: Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци зэрэг байгууллагын эрх зүйн үндсийг хуулиар тогтоож өгөх шаардлагатай.</p>		

**Хавсралт I. Давхардал, зөрчил, хийдлийг тогтооход ашиглах шалгуур,
нэгдсэн дүн**

д/д	ШАЛГУУР	ИЛЭРСЭН ТОО
7.1. ДАВХАРДАЛ		3
1	7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;	-
2	7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;	3
3	7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;	-
4	7.1.4.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардлыг арилгахад чиглэгдсэн эсэх.	-
7.2. Зөрчил		14
5	7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	2
6	7.2.2.хуулийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
7	7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;	2
8	7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх;	2
9	7.2.5.хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;	-
10	7.2.6.тодорхой асуудлыг гагцхүү тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх;	-
11	7.2.7.хуульд заасан эшлэл алдаатай эсэх;	-
12	7.2.8.тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх;	3
13	7.2.9.татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	-
14	7.2.10.тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;	-
15	7.2.11.өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;	-
16	7.2.12.тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх;	1
17	7.2.13. хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх.	4
7.3. Хийдэл		8
18	7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;	2
19	7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;	-

20	7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;	3
21	7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх этгээд нь тодорхой эсэх;	-
22	7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;	-
